

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу “ЮНЕСКО”-ийн Дэлхийн өвийн хорооны XXXIX чуулганы хуралдаанаар Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийг Дэлхийн соёлын өвөөр бүртгэсэнтэй холбогдуулан УИХ-ын 2017 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “ХЭНТИЙ ХААН” уулыг “БУРХАН ХАЛДУН” уул болгон өөрчилж нэрлэх болсон.



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГАЗАРЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

ИРГЭН ТАНЫ ҮҮРЭГ ...

- Уул ус, газар нутгаа түүхэн уламжлалт нэрээр зөв нэрлэж занших;
- Хүүхэд залуучуудыг орон нутгийнхаа түүх, соёлыг мэддэг, газар нутгаа зөв нэрлэж чаддаг байхад анхаарах;
- Түүхэн уламжлалт нэрийг өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх;
- Аливаа газрын зураг, ном товхимолд бичигдсэн газар нутгийн алдаатай нэршлийн талаар аймгийн ГХБХБГ /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/, ГЗБГЗЗГ /Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар/-т мэдэгдэж байх;
- Газар нутаг, уул усны нэрийг шинэчлэхтэй холбоотой аливаа асуудалд идэвхитэй оролцох, санал бодлоо илэрхийлэх;
- ЗГ-ын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах” журамын 4-р заалтын дагуугудамж, зам, талбайг МУ-ын тусгаар тогтнол хөгжил дэвшилд гарамгай гавъяа байгуулсан хүмүүсийн нэр алдрыг мөнхлөх болон түүх соёлын дурсгал, түүхэн уламжлалыг хадгалахад чиглэгдсэнэнгийн ойлгомжтой нэр үгээр нэрлэх асуудалд санал өгөх;

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
Барилгачдын талбай-3, Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын XII байр
Утас: 976-11-329638
Факс: 976-11-329638
И-мэйл: info@gazar.gov.mn
Цахим хаяг: <http://www.gazar.gov.mn/>

ГАЗАР ЗҮЙН НЭР

2018 он

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИАС...

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.5. "газар зүйн нэр" гэж газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор тогтоосон нэрийг;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

11 дүгээр зүйл. Газарзүйннэр

11.3. Газар зүйн нэрэнд дараахь объектын нэр хамаарна:

11.3.1. эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объект;

11.3.2. хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудуу;

11.3.3. улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн доторх хөдөө аж ахуй, үйлдвэр, тээвэр, холбоо зэрэг бусад объект.

11.4. Газар зүйн хуучин нэрийг тодотгох, шинээр тогтоохдоо лавлагааны болон түүхий сурвалжид үндэслэх бөгөөд аливаа эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, мэргэжлийн хүмүүс, судлаачдын саналыг үндэслэн тогтооно.

11.8. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газарзүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна.

12 дугаар зүйл. Хориглохүйлажиллагаа


12.1.3. албан ёсны баримт бичиг, арга хэмжээнд газар зүйн албан ёсны нэрийг өөрчлөн хэрэглэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглах;

ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ТУХАЙ ...

Улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалан түүхэн уламжлал бүхий газар зүйн нэрүүд мартагдах, андуу ташаа нэрлэгдэх болсон тул "Газар нутгийн нэрийг тодруулан тогтоож, журамлах зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн (хуучин нэрээр) 1980 оны 280 дугаар тогтоолоор "Улсын газар нутгийн нэрийн байнгын комисс"-ийг байгуулж байсан.

Уг комиссын тогтоолоор Монгол улсын бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зүйн нэрийг газар дээр нь тодруулан тогтоох ажлыг Улсын Геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/ 1980-1987 онд гүйцэтгэсэн байна. Газар зүйн нэрийн тодруулалтаар 240 гаруй мянган газар зүйн нэрийг тодотгон тогтоосон байдаг.

Газар нутгийн нэрийн зураг ХЭНТИЙ аймаг ӨМНӨДЭЛГЭР сум



2003 онд ГХГЗЗГ Монгол орны 213 мянга гаруй нэрийг УИХ-ын 42 дугаар тогтоолоор батлуулсан.

Газар зүйн нэрийн зүйлчилсэн 8 боть толийг 2004 онд хэвлүүлж нийтийн хүртээл болгож, албан бичиг, ном, товхимол, газрын зураг болон бусад баримт бичигт мөрдүүлэх зорилгоор аймгуудын ГХБХБГ-т хүргүүлсэн.

Газар зүйн нэрийн зүйлчилсэн 8 боть толь

